

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-Т

Захиалагчид гомдол гаргах тухай

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-аас 2024 оны 09 дүгээр сарын 03 ны өдөр зарласан ЭҮТӨҮГ/202401021353 дугаартай тендер шалгаруулалтанд холбогдох хуулийн заалт болон үүсээд буй нөхцөл байдлыг үдэслэн гомдол гаргах нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1 д заасан *-Захиалагч тендер шалгаруулалттай холбоотой хуульд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл сонирхогч этгээд, оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана* гэсний дагуу манай
-нь тендерт оролцох хүсэлтээ 2024 оны 09-сарын 10 ны өдөр цахимаар илгээсэн ба гомдлоо ийнхүү захиалагчид бичгээр гаргаж байна.

Үүнд:

1. ЭҮТӨҮГ/202401021353 дугаартай тендер шалгаруулалтанд тусгагдсан “ Хөдөлгөөнт лазер сканнер LS300 “- ийг Монгол улсад худалдан борлуулах, сургалт хийх эрхийг манай компани эзэмшиж байгаа бөгөөд энэ зорилгоор уул уурхайн компаниудад танилцуулга, сургалт сурталчилгааг явуулдаг.
2024 оны 02-сарын 29-ны өдөр Эрдэнэт үйлдвэрийн ил уурхай болон баяжуулах үйлдвэрт туршилтын хэмжилт, сургалт хийж танилцуулснаар танай Геологи Маркшейдерийн Албаны мэргэжилтнүүд LS 300 багажны техникийн үзүүлэлтийг тендерт оруулах зорилгоор манай компаниас файлаар гаргуулж авсан. Гэтэл уг тендер зарлагдахаас өмнө буюу 2024.08.30 ны өдөр манай компанийн борлуулалт хариуцсан мэргэжилтний WeChat хаягт нэгэн иргэнээс манай компаниас бэлтгэж явуулж байсан дээр дурьдсан техникийн үзүүлэлт бүхий файлыг яг тэр форматаар нь илгээж үнийн санал авахыг хүссэн байна . Энэ нь уг тендер зарлагдахаас өмнө танай холбогдох хүмүүс нууц мэдээллийг задруулж хууль зөрчсөн ба бусдад давуу эрх олгох, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн гэж үзэж байна./ *баримтыг хавсаргав/*
2. LS 300 Багаж нь маркшейдерийн өдөр тутмын хэмжилтийн ажилд хэрэглэгддэг бөгөөд ямар нэгэн цацраг идэвхи байхгүй , худалдах, хэрэглэхэд цацраг идэвхийн тусгай зөвшөөрөл шаарддаггүй төхөөрөмж юм. Гэтэл уг тендерийн **ТШЗ 18.2 -т Цацрагийн хяналтын систем Фрегат системийг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь III бүлгийн "Бараа нийлүүлэлтийн хуваарь"-ийн 7 дугаар багана буюу нийлүүлэгчийн санал болгох хугацаа дуустал хүчинтэй байна** гэж тусгажээ.

Энэ нь маркшейдерийн багажтай огт хамааралгүй геофизикийн цацраг идэвхит багажнуудыг худалдаж авах тендерийн багцад санаатайгаар оруулж тухайн тусгай зөвшөөрөл эзэмшдэг компанид давуу эрх олгохыг завдсан гэж үзэж байна.


Иймээс дээр дурьдсан ноцтой зөрчлүүдийг үндэслэж ЭҮТӨҮГ/202401021353 дугаартай тендер шалгаруулалтыг цуцлаж, бусад оролцогч, сонирхогч эдгээдүүдэд шударгаар өрсөлдөх боломжийг олгоно уу.

Жич: Бидний хүсэлтийг хүлээж авч хуулийн дагуу ажиллана гэдэгт найдаж байна. Эс тохиолдолд хуульд заасны дагуу дараагийн шатны байгууллага, шүүхэд хандаж шударга өрсөлдөөний төлөө тууштай ажиллах болно. Шаардлагатай тохиолдолд дуу бичлэг, холбогдох и -мэйлүүдэд үзлэг хийлгэж болно.

Гомдол гаргасан :

Гүйцэтгэх захирал

Хавсралт 1



Хавсралт 2

№	Төрөл	Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ	Стандарт	Тайлбар
1	Загвар/модель	SnioGNSS ComNav technology SLAM				
2	Технико-технологийн үзүүлэлт	LS300				
3	Технико-технологийн үзүүлэлт	Овоор хэмжээ	кг	1.5		
4	Технико-технологийн үзүүлэлт	Ажиллах нөхцөл	°C	-35~+60		
5	Технико-технологийн үзүүлэлт	Тасралтгүй ажиллах хугацаа	цаг	4 /Нот ямар дэвжээ/		
6	Технико-технологийн үзүүлэлт	Баттерей багтааж	Ватт.цаг/А.цаг	98 Ватт.цаг/6.8А.цаг		
7	Технико-технологийн үзүүлэлт	Дүнжилт хийх зэрэг	метр	120		
8	Технико-технологийн үзүүлэлт	Уг ширээ тусны хангаалалт		IP54		
9	Технико-технологийн үзүүлэлт	Дата гаргах формат		csv, xml, pdf, jpg, etc.		
10	Технико-технологийн үзүүлэлт	Нарийвчлал	см	1		
11	Технико-технологийн үзүүлэлт	Өвөрмөц санхуйн багтааж	GB	500		
12	Технико-технологийн үзүүлэлт	Камер дэвжээ		Панорамик камер		
13	Технико-технологийн үзүүлэлт	Зург		Панорамик камер		
14	Технико-технологийн үзүүлэлт	Камерын хүчин чадал	мегапиксел	96 MP /5.7K видео бичлэг/		
15	Технико-технологийн үзүүлэлт	Камерын харгах өнцөг	цаг/секунд	320,000,000		
16	Технико-технологийн үзүүлэлт	Хангам		Wi-Fi		
17	Технико-технологийн үзүүлэлт	RGB Өнгөт цэвэр дат дэвжээ				
18	Технико-технологийн үзүүлэлт	Лазерын ангилал		1-р зэрэг		
19	Технико-технологийн үзүүлэлт	Лазер гэрлийн шугам	шугам	16		
20	Технико-технологийн үзүүлэлт	Ажил эрхэлт		Hybrid алгоритм		
21	Технико-технологийн үзүүлэлт	Үүргэлтэй хэмжээт хийх иж бүрдэл /Backup/	цаархэг		1 LS 300 лазер сканнерийг гадна орчинд хэмжээт хийхэд зориулсан үүргэн болон бусад дагалдах эргэлтийн хэвт	
22	Технико-технологийн үзүүлэлт	Car Mount	цаархэг		1 LS 300 лазер сканнерийг авто машинд суурилуулах төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийн хэвт	
23	Технико-технологийн үзүүлэлт	OSN Модуль /Хангамч/	цаархэг		1 LS 300 лазер сканнерд гарна орчинд хэмжээт хийхэд GNSS хүлээн авагчтай хангах модуль	
24	Технико-технологийн үзүүлэлт	Ажиллах горим			Хэмжээтэй үр дүг Андройд үйлдвэрийн системд багтат ашигшиг /Realtime/ шууд хөндөг байх	
25	Технико-технологийн үзүүлэлт	Дата боловсруулалт			Хэмжээтэй үр дүг бүхий өнгөт болон ердийн цэвэр дат-г хэзэийн нөхцөлд өөр дээрээ шуурхай боловсруулдаг, компьютерт багн модель оруулдаг байх.Өгөг	
26	Технико-технологийн үзүүлэлт	Үйлдлийн горим			Стандарт хэмжээтээс гадна өнгөт цэвэр дат болдог байх бөгөөд үг дата дээр чүүлүлгийн хил заагийн дагуу тэжиргээг хийж зурах, тэжиргээг зургийг Auto	